<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,879,926,900.00</b>	<b>1,812,246,116.56</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,130,309,200.00</b>	<b>1,086,240,758.69</b>
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,059,866,000.00	1,015,797,558.69
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	70,443,200.00	70,443,200.00
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>581,296,000.00</b>	<b>577,467,617.41</b>
320001	Орон нутгийн төсвөөс	581,296,000.00	577,467,617.41
<b>33</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>20,399,900.00</b>	<b>19,827,550.00</b>
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	20,399,900.00	19,827,550.00
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>147,921,800.00</b>	<b>128,710,190.46</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	120,000,000.00	128,710,190.46
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	27,921,800.00	0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл□	0	95,873,848.41
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл□	0	165,211,498.27
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>500</b>	<b>423</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>6</b>	<b>6</b>
610001	Төсвийн байгууллага	6	6
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>99</b>	<b>97</b>
620001	Удирдах ажилтан	13	13
620002	Гүйцэтгэх ажилтан	53	50
620003	Үйлчлэх ажилтан	28	28
620004	Гэрээт ажилтан	5	6

**Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>238,540,530.65</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>238,540,530.65</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>184,544,266.04</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>2,013,299.00</b>
210401	Бичиг хэрэг	53,849.00
210402	Тээвэр, шатахуун	1,457,250.00
210404	Ном, хэвлэл	502,200.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>6,000,000.00</b>
210604	Урсгал засвар	6,000,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,941,600.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,941,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>22,826,271.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,826,271.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>151,763,096.04</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	151,607,096.04
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	156,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>53,996,264.61</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>34,172,000.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,923,100.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	13,240,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,008,000.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>19,824,264.61</b>
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	19,814,864.61
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	9,400.00
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>238,540,530.65</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>238,540,530.65</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	15,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	186,988,274.65
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	36,052,256.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд татварын орлогын болон зээлийн авлагын мэдээ тайлан гаргалттай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Хүрэлбаатар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 02/40 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг дарга нь төрийн үйлчилгээг иргэдэд чанартай хүртээмжтэй хүргэх зорилго бүхий аймгийн Засаг даргын харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө бага байна.

Сэргэлэн сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй, нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцүүлэн Сангийн сайдын 2006 оны 388, 2015 оны 341 тоот тушаалаар баталсан загвар, аргачлалыг баримтлан тайлагнаж байна.

Сэргэлэн сумын Засаг даргын 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн А/94 дүгээр тушаалаар томилогдсон 5 хүний бүрэлдэхүүнтэй баг хяналтыг хэрэгжүүлдэг байна. Аймгийн Засаг даргаас жилд 2 удаа бүх сум байгууллагад нэрэмжит үзлэг, Санхүүгийн хяналт аудитын алба удирдамж төлөвлөгөөний дагуу хяналт шалгалт явуулдаг, байгууллага бүрд дотоод хяналтын нэгж ажилладаг боловч сумын хэмжээнд төсөв санхүүгийн сахилга бат сайжирч, алдаа зөрчил буурахгүй байна. Цаашид анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтлөлт, хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах талаар дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сэргэлэн сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн тайлангийн орлого үр дүнгийн тайлангийн нийт орлогыг суурь үзүүлэлтийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 2,820,792.7 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 42,311.8 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 31,733.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг дарга нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, ЗЗНДНТУТХ, Шилэн дансны тухай хууль, ТБОНӨ-ийн тухай хууль болон холбогдох бусад хууль дүрэм зааврыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсөвт байгууллага, төрийн сан, Сум хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сан, Эмийн эргэлтийн сан, Байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сан зэрэг 11 санхүүгийн тайланг нэгтгэн тайлагнасан байна.

Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд Сангийн яамны Э тайлангийн нэгтгэлийн систем программыг ашиглаж байна.

#### **Орлогын талаар:**

Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа байгууллагууд тусгай зориулалтын шилжүүлгээс 1,059,866.0 мянган төгрөг, орон нутгийн төсвийн 50,825.6 мянган төгрөг, Эрүүл мэндийн даатгалаас 19,827.5 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангийн 70,443.2 мянган төгрөг, Төсөвт байгууллагын өөрийн орлого 157,922.6 мянган төгрөг, торгуулийн орлого 90,945.9 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансанд 217,588.7 мянган төгрөг, татварын орлого 543,481.9 мянган төгрөг, нийт 2,441,074.3 мянган төгрөгийн орлого, эх үүсвэрийг төвлөрүүлэн зарцуулсан байна.

Сэргэлэн сумын ИТХ-ын Хуралдааны 2021 оны 9 дүгээр сарын 06-ны өдрийн 31 дугаар тогтоолоор сумын орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлогыг нийт 530,470.4 мянган төгрөгөөр баталсан байна.

**Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Орон нутгийн төсөвт 2021 онд татварын орлого 543,953.1 мянган төгрөг, татварын бус орлого 324,823.4 мянган төгрөг, нийт 868,776.5 мянган төгрөг төвлөрч, батлагдсан төлөвлөгөөг 338,306.1 мянган төгрөг буюу 1.6 дахин биелүүлсэн байна. Орон нутгийн орлогын төлөвлөгөө өндөр хувиар биелэхэд сумын Засаг даргатай байгуулсан Идлэг шонхор шувуу бариулах тухай гэрээний дагуу 684,243.2 мянган төгрөгийн орлого төвлөрсөн нь нөлөөлсөн байна.

**Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:**

Үндсэн хөрөнгө дансанд 20,584.8 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 410,381.6 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор нийт 430,966.4 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэсэн ба 128,213.0 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, данснаас хассан байна.

Бараа материалын дансанд худалдан авсан 334,008.1 мянган төгрөгийн, үнэ төлбөргүй хүлээн авсан 118,017.3 мянган төгрөгийн, нийт 452,025.4 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 386,329.1 мянган төгрөгийн бараа материалыг хассан байна

**Авлага, өглөгийн талаар:**

Санхүүгийн нэгтгэсэн тайланд байгууллагаас авах 31,242.6 мянган төгрөг, хувь хүмүүсээс авах 177,491.4 мянган төгрөг, эргэлтийн эмийн сангийн авлага 1,188.7 мянган төгрөг, нийт 209,922.8 мянган төгрөгийн авлага нэгтгэгдсэн байна. Нийт авлагын 175,198.7 мянган төгрөг буюу 83,4 хувийг сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага эзэлж байна.

Ажилчидтай холбогдсон өглөг 367.1 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлын өглөг 20.0 мянган төгрөг, байгууллагад төлөх 8,101.4 мянган төгрөг, хувь хүмүүст төлөх өглөг 291.1 мянган төгрөг, нийт 8,779.6 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй нэгтгэгдсэн байна.

**Санхүүгийн байдлын тайлангийн талаар:**

Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайланд 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн харилцах дансанд 563,220.9 мянган төгрөг, арилжааны банк дахь харилцах дансанд 2,133.6 мянган төгрөг, бэлэн 40.5 мянган төгрөг, нийт 565,395.1 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нэгтгэгдсэн байна.

Бараа материал 305,710.1 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 3,097,743.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	832,130.3	565,395.1	-266,735.2
Авлага	233,934.1	209,922.8	-24,011.2
Урьдчилгаа			
Бараа материал	240,013.7	305,710.1	65,696.3
Үндсэн хөрөнгө	2,974,794.3	3,097,743.5	122,949.1
<b>Нийт хөрөнгө</b>	<b>4,280,872.6</b>	<b>4,178,771.6</b>	<b>-102,100.9</b>
Өр төлбөр	683,237.6	8,779.6	-674,457.9
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,597,635.0	4,169,992.0	572,357.0
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>4,280,872.6</b>	<b>4,178,771.6</b>	<b>-102,100.9</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 305,710.1 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 65,696.3 мянган төгрөгөөр өссөн нь эм, боох материал, бичиг хэрэг, хүнсний материалын үлдэгдэл өмнөх оноос өссөнөөс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,097,743.5 мянган төгрөг болж 122,949.1 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй авсан үндсэн хөрөнгөөс шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,169,992.0 мянган төгрөг болж 572,357.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Сэргэлэн сумын ИТХ-ын Хуралдааны 2020 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн “2021 оны төсөв батлах тухай” 09 дүгээр тогтоолоор 2021 онд төсөвт төвлөрүүлэх татварын ба татварын бус орлогыг 530,470.4 мянган төгрөгөөр, зарлагын нийт хэмжээг 1,614,304.0 мянган төгрөгөөр баталсан байна. Сумын ИТХ-ын Хуралдааны 2021 оны 9 дүгээр сарын 06-ны өдрийн 31 дүгээр тогтоолоор 2021 оны төсвийн жилд орон нутгийн хөгжлийн санд олгох шилжүүлгийн хэмжээг 70,443.2 мянган төгрөгөөр, тусгай зориулалтын шилжүүлгийн хэмжээг 1,059,584.3 мянган төгрөгөөр тус тус тодотгон баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн зарлагын нийт хэмжээг 2,750,703.4 мянган төгрөгийн төсөв баталсан.

Нийт зардлын 246,566.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, 47,049.1 мянган төгрөгийг урьд оны шилжих үлдэгдлээс, 354,206.8 мянган төгрөгийг ОНХС-ийн шилжих үлдэгдлээс, 22,084.7 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 1,065,686.7 мянган төгрөгийг аймгийн төсвөөс тусгай зориулалтын шилжүүлэг, 483,365.1 мянган төгрөгийг аймгаас ОНХС-д санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 1,607,448.6 мянган төгрөгийг урсгал зардалд, 59,453.2 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 76,006.6 мянган төгрөгийг эргэн төлөгдөх зээлийн зардалд, нийт 1,742,908.4 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 44,068.4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,441,074.3 мянган төгрөг буюу 71,1 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд санхүүгийн нэгтгэсэн тайланд 238,540.5 мянган төгрөгийн эх үүсвэрийг төвлөрүүлэн, бараа, ажил үйлчилгээний зардалд 184,544.2 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлэг буюу нэг удаагийн мөнгөн тэтгэмж, дэмжлэг, урамшуулалд 34,172.0 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 19,824.2 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Сэргэлэн сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсөвт байгууллагууд, тусгай зориулалттай сангуудын санхүүгийн тайлангийн аудитын талаар:

- Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудиторуд нь тус сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, ИТХ, Соёлын төв, ОНХС, СХС, Байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сан, эмийн эргэлтийн сангийн тайланг түүвэрт хамруулан шалгасан. Аудитаар ЗДТГ-т 1,576.9 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 145,571.8 мянган төгрөгийн 7 албан шаардлага, 1 зөвлөмж, ИТХ-д 8,460.6 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 2,088.9 мянган төгрөгийн 1 зөвлөмж, соёлын төвд 8,938.8 мянган төгрөгийн 2 албан шаардлага, сум хөгжүүлэх санд 1,089.7 мянган төгрөгийн 1 зөвлөмж, 29,512.3 мянган төгрөгийн 2 албан шаардлага тус тус өгөгдсөн.
- Төв аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний үндсэн дээр Гэрэлтэх бүртгэл аудит ХХК тус сумын ЕБС, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв гэсэн 3 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргасан. Аудитаар эргэлтийн эмийн сангийн санхүүгийн тайланд 225.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж, 1,188.8 мянган төгрөгийн 1 албан шаардлага, эрүүл мэндийн төвд 18,000.8 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 352,966.6 мянган төгрөгийн 3 зөвлөмж, ерөнхий боловсролын сургуульд 6,343.6 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 4,933.5 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 383,988.9 мянган төгрөгийн 4 зөвлөмж, хүүхдийн цэцэрлэгт 3,816.1 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 3,035.5 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 349,834.3 мянган төгрөгийн 3 зөвлөмжийг тус тус хүргүүлсэн байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Сумын орлогын төлөвлөгөөг нийт дүнгээр биелүүлсэн боловч Үйл ажиллагааны орлогын албан татвар, тэмдэгтийн хураамж, ТТАМ ашигласны төлбөр, газрын төлбөр гэсэн 4 нэр төрлөөр тасалсан зөрчилд зөвлөмж өгсөн.

Сумын нэг нягтлан бодогч 5 байгууллагыг хариуцаж санхүүгийн үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байна. Энэ нь ажлын ачаалал их байгаагаас шалтгаалж ажил хаягдах, хугацаа хоцрох, алдаа гарах эрсдэлийг үүсгэж байна.

Нийгмийн хариуцлагын гэрээг байгуулахдаа орон нутгийн нийт ард иргэдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхээс илүү төрийн байгууллагын эд хогшил, хэрэгцээ шаардлагыг биелүүлэх шинжтэй байгуулж байна. Тиймээс цаашид нийгмийн хариуцлагын гэрээг байгуулахдаа ард иргэдийн саналыг авч, эрэмбэлж тусгаж байх.

Сургууль, Цэцэрлэг, Засаг даргын Тамгын газарт бараа материал нөөцөлдөг зөрчил байсаар байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цэсэнд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 146 мэдээллээс хугацаандаа мэдээлсэн 129 мэдээлэл, хугацаа хоцроосон 17 мэдээлэл байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн 1 зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн 02/204 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн орлогын талаар дараагийн аудитаар анхаарал хандуулах зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,480,108.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 91,857.2 мянган төгрөгийн алдааг залруулж, 12,068.7 мянган төгрөгийн 6 төлбөрийн акт, 240,454.2 мянган төгрөгийн 18 албан шаардлага, 1,135,727.9 мянган төгрөгийн зөрчилд 16 зөвлөмж өгөв.

### 4.3 Албан шаардлага

Соёлын төв, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Эргэлтийн эмийн сангийн харилцагч байгууллагатай хийсэн 12,827.6 мянган төгрөгийн худалдан авалт нь цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6-д "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй", Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөн заавар"-ын 6.5-д Төлбөрийн баримт "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ", санхүүгийн тайлангийн аудитын "Иж бүрэн байх", "Эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-дэх заалт болон Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1 "Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

Засаг даргын санхүүгийн тайланд нийгмийн хариуцлагын гэрээний хүрээнд 20,812.0 мянган төгрөгөөр Засаг даргын өрөөг тохижуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар бүлгийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 25 дугаар зүйлийн 25.5-д "Дараах тохиолдлыг ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзэн төсвийн байгууллага

хандив, тусламж авахыг хориглоно”, 25.5.2-т “байгууллагын ажилтны энэ хуулийн 25.4.2-т зааснаас бусад нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилготой байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-дэх заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэсэн дагуу шийдвэрлэв.

Сум хөгжүүлэх сангийн авлагын үлдэгдлийг тооцоо хийж, баталгаажуулсан байдал болон зээлийн хугацаа хэтрэлтийг зээлдэгч бүрээр тулгахад 26,448.5 мянган төгрөгийн хугацаа хэтрэлттэй, хүүгийн орлогын 50 хувиас илүү зардал гаргасан зөрчлүүд байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-дэх заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “авлага, өглөгийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй” бол албан шаардлага өгөх гэсэн дагуу шийдвэрлэв.

#### **4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### **1. Орлоготой холбоотой асуудал**

###### **1.1. Илрүүлэлт:**

Сумын орлогын төлөвлөгөөг нийт дүнгээр биелүүлсэн боловч Үйл ажиллагааны орлогын албан татвар, тэмдэгтийн хураамж, ТТАМ ашигласны төлбөр, газрын төлбөр гэсэн 4 нэр төрлөөр тасалсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д “Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ”, 41.2.1-д “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

###### **Өгсөн зөвлөмж:**

Орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн татварын болон татварын бус орлогыг мэдээлэхдээ орлогын дансны хуулгыг боловсруулан үнэн зөв мэдээлж байх ба түүнд тавих хяналтыг сайжруулах

##### **2. Тайлан, мэдээ гаргалттай холбоотой асуудал**

###### **2.1. Илрүүлэлт:**

Сум хөгжүүлэх санхүүгийн тайлангийн авлагын үлдэгдлийг аймгийн ХХААГ-аас ирүүлсэн сангийн авлагын дүнтэй тулгахад 1,089.7 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан

**Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Сум хөгжүүлэх сангийн авлагын дүнг ХХААГ-ийн тайлангаас зөрүүтэй мэдээлж буй зөрчлийг арилгаж, зээл, зээлийн хүүгийн авлагын үлдэгдлийг зөрүүгүй үнэн зөв тайлагнаж байх.

**3. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

**3.1. Илрүүлэлт:**

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь дотоод аудитын хяналт шалгалтаар албан хаагчид дээр тогтоогдсон 2,088.9 мянган төгрөгийн төлбөрийн актын төлбөрийг төсвөөс төлж авлага үүсгэж байгаа нь тухайн жилд төлөвлөгдсөн арга хэмжээ, үйл ажиллагаа хийгдэх эх үүсвэргүй болгож байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Албан хаагчид дээр тогтоосон төлбөрийн актыг тухайн албан хаагчаар төлүүлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

д/ д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
	Сэргэлэн Засаг дарга	45	1,480,108.1	5	91,857.2	6	12,068.7	18	240,454.2	16	1,135,727.9